This file has been cleaned of potential threats.

If you confirm that the file is coming from a trusted source, you can send the following SHA-256 hash value to your admin for the original file.

2328d0884b7ab10a1b55dea2a196185b1addea8756e6c2da8725247fa821a489

To view the reconstructed contents, please SCROLL DOWN to next page.

# ИНТЕРНЭТ БАНКНЫ ҮЙЛЧИЛГЭЭ

## Хэрэглэгчийн гарын авлага 2015



www.e-nibank.mn

# АГУУЛГА

**ТАНИЛЦУУЛГА:**

- Интернэт банк
- Интернэт банкны үйлчилгээ
- Хэрэглэгчийн эрхийн түвшин
- Нэвтрэх, нууц үг солих

**ДАНС**:

- Дансны жагсаалт
- Дансны хуулга
- Данс нэмэх, тохируулах
- Шинээр данс нээх
- Данс битүүмжлэх

**ГҮЙЛГЭЭ**:

- Өөрийн данс хооронд
- ҮХОБанкны данс хооронд
- Банк хооронд
- Гадаад гуйвуулга
- Багц гүйлгээ
- Гүйлгээний загвар
- Гүйлгээ хайх

**ТӨЛБӨР**:

- Гар утас, кабелийн төлбөр төлөх

**ОНЛАЙН ЗАХИАЛГА**:

- Захиалгат шилжүүлэг
- Миний мэдээ
- Хадгаламжийн хугацаа сунгах
- Картын захиалга
- Дансны тодорхойлолт

**ЗЭЭЛ:**

- Хадгаламж барьцаалсан зээл
- Зээлийн төлбөрийн хуваарь

# 1. ТАНИЛЦУУЛГА

## 1.1. Интернэт банк

Та цаг хугацаа, орон зайнаас үл хамааран банкны бүх төрлийн үйлчилгээг тvргэн шуурхай, найдвартай гvйцэтгэх боломжоор хангагдана.

Та Интернэт банкны хэрэглэгч болсноор:

- Хүссэн үедээ
- Таарсан газраа
- Хялбар арга
- Хямд зардал
- Найдвартай замаар
- Цагаа хэмнэн єєрийн мєнгєн хєрєнгийг захиран зарцуулах боломжтой болж байна.

## 1.2. Интернэт банкны үйлчилгээ

Та дараах үйлчилгээг авах боломжтой:

**ДАНС**:

- Дансны жагсаалт
- Дансны хуулга
- Данс нэмэх, тохируулах
- Шинээр данс нээх
- Данс битүүмжлэх

**ГҮЙЛГЭЭ**:

- Өөрийн данс хооронд
- ҮХОБанкны данс хооронд
- Банк хооронд
- Гадаад гуйвуулга
- Багц гүйлгээ
- Гүйлгээний загвар
- Гүйлгээ хайх

**ТӨЛБӨР**:

- Гар утас, кабелийн төлбөр төлөх

**ОНЛАЙН ЗАХИАЛГА**:

- Захиалгат шилжүүлэг
- Миний мэдээ
- Хадгаламжийн хугацаа сунгах
- Картын захиалга
- Дансны тодорхойлолт

**ЗЭЭЛ:**

- Хадгаламж барьцаалсан зээл

- Зээлийн төлбөрийн хуваарь

**БУСАД ҮЙЛЧИЛГЭЭ:**

- Мэдээллийн самбар
- Валютын ханш
- Туслах үйлчилгээ

**ТУСЛАМЖ:**

- Харилцагчийн мэдээлэл
- Гарын авлага
- Нэвтрэх нууц үг солих
- Ханш бодох
- Холбоо барих

### 1.3. Хэрэглэгчийн түвшин

Интернэт банкны хэрэглэгч болохын тулд та:

1. Тус банкинд харилцах хадгаламжийн болон бусад данстай байх
2. Тогтмол хэрэглэдэг и-мэйл хаягтай байх
3. Гүйлгээ хийх эрхтэй хэрэглэгч бол Java дэмждэг болон IOS үйлдлийн системтэй интернет холболттой гар утастай байх ба та байгууллагын хэрэглэгч бол өөрийн байгууллагынхаа бичиг баримт, тамга тэмдэг, гүйлгээ хийх эрх бүхий этгээдийн нэг ба хоёрдугаар гарын үсэг зэргийг бүрдүүлж өөрийн биеэр ҮХОБанкны аль нэг онлайн салбар нэгж дээр ирж үйлчилгээний нөхцөлтэй танилцан, I эсвэл II зэрэглэлээс сонгож гэрээ байгуулснаар Интернэт банкинд нэвтрэн орох Хэрэглэгчийн нэр, Нэвтрэх нууц үг–ээр эрхээ нээлгэнэ. Гэрээ байгуулж бүртгүүлсэнээс хойш 24 цагийн дотор үйлчилгээний эрх нээгдэнэ.

I зэрэглэл: Өөрийн дансны мэдээллийг шалгах, лавлагаа хийх, валютын албан болон арилжааны ханшийн мэдээ авах, банкинд хүсэлт илгээх эрхтэй хэрэглэгч.

II зэрэглэл: I зэрэглэлийн бүх үйлчилгээн дээр банк хоорондын болон ҮХОБанкны данс хоорондын гүйлгээ хийх, зээлийн төлбөр төлөх зэрэг гүйлгээ хийх үйлчилгээ нэмэгдэх ба гар утсан дээрээ нэг удаагийн нууц үг үүсгэх программыг суулгана.

### 1.4. Нэвтрэх, нууц үг солих

Та www.e-nibank.mn хаягаар Интернэт банкны сайт уруу орно.

Үйлчилгээнд анх нэвтэрч буй хэрэглэгч нь нэвтрэх нууц үгээ солих шаардлагатай бөгөөд шинэ нууц үгээ оруулж “Хадгалах” товчийг дарж хадгалаад дахин шинэ нууц үгээрээ орох шаардлагатай.




Харилцагч нэвтрэн ороход хамгийн эхний үндсэн цэс болох Дансны цэсний Дансны жагсаалт дэд цэсний мэдээлэл гарах болно

## 2. ДАНС



### 2.1. Дансны жагсаалт

Таны интернэт банкинд бүртгүүлсэн харилцах, хадгаламж, зээлийн гээд таны бүх дансууд байх ба дэлгэрэнгүй хэлбэрээр нь харахыг хүсвэл сонгосон дансны дугаар дээрээ дарахад болно. Та эндээс дансны дугаар, дансны нэр, бүтээгдэхүүний нэр, үлдэгдэл, статус, данс нээсэн огноо, сүүлд хийсэн гүйлгээний тоо, хуримтлагдсан хүү зэрэг тухайн данстай холбоотой бүхий л мэдээллүүдийг харах боломжтой.

### 2.2. Дансны хуулга

Та єєрийн дансны хєдєлгєєнийг харах, хэвлэж авах шаардлагатай бол данс, хамрагдах хугацааг сонгон “Харах” товчийг дарна. Хэвлэж авах шаардлагатай бол pdf, excel хувилбараар сонгон хэвлэх боломжтой.

### 2.3. Данс нэмэх, тохируулах

Та өөрийн данснуудаас ашиглагдахгүй байгаа дансаа хаах, эргүүлж нээх боломжтой.

### 2.4. Шинээр данс нээх

Харилцагч нь харилцах данс, хугацаатай, хугацаагүй хадгаламжийн данс онлайнаар нээх боломжтой.

### 2.5. Данс битүүмжлэх

Хэрэв та төлбөрийн картаа алдсан болон бусад тохиолдолд дансаа битүүмжилж зарлагын гүйлгээ хийх боломжгүй болгох боломжтой бөгөөд заавал салбар дээр өөрийн биеэр ирж битүүмжээ чөлөөлүүлнэ.

## 3. ГҮЙЛГЭЭ



Гүйлгээ цэсийг ашиглан 5 төрлийн гүйлгээ хийх, гүйлгээг урьдчилан захиалах болон байнга хийдэг гүйлгээг загвар болгон хадгална.

Хэрэглэгчийн зэрэглэл 1 нь зөвхөн дансаа шалгах эрхтэй бөгөөд Зэрэглэл 2 хэрэглэгч нь зэрэглэл 1 хэрэглэгчийн бүх үйлчилгээг авахаас гадна гүйлгээг баталгаажуулан хийх эрхтэй.

### 3.1 Өөрийн данс хооронд

Интернэт банкны үйлчилгээнд бүртгэлтэй өөрийн дансдын хооронд гүйлгээ хийхэд **Гүйлгээ – Өөрийн данс хооронд** цэсийг ашиглана.

Аливаа гүйлгээг хийхийн тулд 3 алхамаар хийх бөгөөд (1) гүйлгээ оруулах, (2) гүйлгээ батлах, and (3) гүйлгээний үр дүн гэсэн байдлаар хийнэ.

- Иргэдийн хувьд 5 сая төгрөг түүнтэй тэнцэх хэмжээний бусад валютаар гүйлгээ хийхдээ “Нэвтрэх нууц үг”-ээр баталгаажуулан гүйлгээ хийх бөгөөд бусад тохиолдолд нэг удаагийн нууц үг ашиглан гүйлгээг хийнэ.
- Байгууллагын харилцагчийн хувьд аливаа гүйлгээг хийхдээ “нэг удаагийн нууц үг” ашиглан хийнэ.

### 3.2 ҮХОБанкны данс хооронд

Интернэт банкинд бүртгэлтэй данснаас ҮХОБанкны дурын данс руу шилжүүлэг хийхэд **Гүйлгээ – ҮХОБанкны данс хооронд** цэсийг ашиглана.

### 3.3 Банк хооронд

**Гүйлгээ – Банк хооронд** цэсийг ашиглан ҮХОБанкнаас бусад банкны данс руу шилжүүлэг хийнэ. ҮХОБанкны данс хооронд гүйлгээ хийхээс ялгаатай нь хүлээн авагчийн Банкны нэрийг сонгох бөгөөд системээс хүлээн авагчийн данс болон нэрийг урьдчилан шалгах боломжгүй тул мэдээллээ сайтар шалгана уу.

### 3.4 Гадаад гуйвуулга

Гадаад орнууд руу SWIFT сүлжээгээр дамжуулан гүйлгээ хийх хүсэлт илгээхэд **Гүйлгээ – Гадаад гуйвуулга** цэсийг ашиглана. Гадаад гуйвуулгын маягтын “Шилжүүлэгч, хүлээн авагчийн мэдээлэл” хэсэгт шаардлагатай бүх мэдээллийг оруулна.

Мєн та энэ хэсэгт “Дамжуулагч банкны шимтгэл тєлєх хэлбэр” сонголтыг заавал анхаарч сонголтыг хийх хэрэгтэй.

Таны 16 цагаас хойш хийж байгаа банк хоорондын гүйлгээ дараагийн ажлын єдєрт шилжиж хийгдэхийг анхаарна уу!

### 3.5 Багц гүйлгээ

Хэрэв та байгуулагын хэрэглэгч бол “Багц гүйлгээ хийх” товчийг дарахад сонгогдсон загварын дагуу байгууллагын цалин тавих гүйлгээг хийх боломжтой.

### 3.6 Гүйлгээний загвар

Олон давтамжтай хийгддэг гүйлгээний мэдээллийг загвар болгон хадгалсанаар харилцагч нэг ижил мэдээллийг дахин дахин оруулах шаардлагагүй болно. Үүний тулд бүх төрлийн гүйлгээний мэдээлэл баталгаажуулах цонхонд байрлах “Гүйлгээг загвар болгон хадгалах” холбоосыг ашиглана. Гүйлгээ захиалахаас ялгаатай нь энэ тохиолдолд гүйлгээг автоматаар хийхгүй, зөвхөн гүйлгээний маягтыг бөглөх явцыг хялбарчилах юм.

### 3.7 Гүйлгээ хайх

Дансны дугаар, хийгдсэн хугацаа, мөнгөн дүнгээ оруулан өмнө нь хийгдэж байсан гүйлгээгээ хайх болмжтой.

## 4. ТӨЛБӨР




Харилцагч гар утасны төлбөр болон кабелийн телевизийн төлбөрөө төлөх боломжтой.

## 5. ОНЛАЙН ЗАХИАЛГА




### 5.1 Захиалгат шилжүүлэг

Интернэт банкны Онлайн захиалга цэсэнд байрлах “Захиалгат шилжүүлэг” цэсний тусламжтайгаар тогтмол дүнтэй, тодорхой давтамжтай хийгддэг болон нэг удаагийн гүйлгээг урьдчилан захиалах боломжтой. Ийнхүү захиалснаар таны сонгосон хугацаанд уг гүйлгээ автоматаар хийгдэх болно.

### 5.2 Миний мэдээ

Миний мэдээ мессежээр мэдээлэл өгөх үйлчилгээ нь таны дансны орлого, зарлагыг тухай бүрд нь мессежээр мэдээлдэг. Та тус үйлчилгээнд дуртай дансаа сонгон шимтгэлийн төлж идэвхижүүлэх боломжтой.

### 5.3 Хадгаламжийн хугацаа сунгах

Та хадгаламжийн дансны хугацаагаа сунган баталгаажуулах боломтой.

### 5.4 Картын захиалга

Төлбөрийн картын хугацаа дууссан эсвэл хаяж үрэгдүүлсэн тохиолдолд картаа онлайнаар захиалж аваарай.

### 5.5 Дансны тодорхойолт

Дансны тодорхойлолтыг зайнаас авахын тулд “Онлайн захиалга” цэснээс “Дансны тодорхойлолт авах” сонголтыг сонгоно. Дансны тодорхойлолт авах хүсэлтийн мэдээлэл оруулах талбарууд гарч ирэх ба шаардлагатай утгуудыг оруулж хүсэлтээ илгээнэ.

# 6. ЗЭЭЛ




## 6.1 Хадгаламж барьцаалсан зээл

"Хадгаламж барьцаалсан зээл"-ийн хүсэлт илгээн зээл авч болох ба зээлийн хүсэлтийг зааврын дагуу илгээнэ.

## 6.2 Зээлийн төлбөрийн хуваарь харах

Зээл төлөх хуваариа харах боломтой.